

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ЗАА-2026/018/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2026 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarakh@audit.gov.mn

“Алтан-Тосон аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал
Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: altantosonaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улаанбаатар сум, Завхан аймаг 81090
Утас/Факс: 7046-3612
Цахим илүүдэл: zavkhan.audit.gov.mn

2025.08.15 № 150
Төвийн _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭХАЙРХАН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Н.СОСОРБУРАМ-д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуульд хандив тусламжаар 26,318.00 төгрөгийн тоног төхөөрөмж, 7,277,930 төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 63,499,332 төгрөгийн тавилга эд хогшил, 7,027,131.84 төгрөгийн ном нийлүүлэгдсэнийг бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан томилолтоор ажилласан албан хаагчдад 85,000 төгрөгийн хоолны зардлыг давхардуулан олгосон, ёс зүйн дээд хорооны гишүүдэд 1,892,484 төгрөгийн урамшуулал олгосон, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт аймгийн

D:\Анбан бичиг\А4-2026.docx

812605337

Боловсролын газар, Монгол Улсын Боловсролын Их сургууль, Эрдэмтэн сурагчдын хөгжлийн институт, Монголын хүний нөөцийн хүрээлэнгээс эрүүл мэндийн мэдлэг дээшлүүлэх, Айуконы сургалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтуудыг авч, 2,309,000 төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	320,036,824.25	242,502,228.43
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	210,999,588.32	132,543,550.66
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	210,999,588.32	132,543,550.66
17	Төрийн сангийн харилцах	210,999,588.32	132,543,550.66
60	БАРАА МАТЕРИАЛ	109,037,235.93	109,958,677.77
61	Түүхий эд материал	63,091,242.85	56,503,702.85
62	Тусгай зориулалттай материал	62,923,242.85	56,394,702.85
63	Эм боох материал	168,000.00	109,000.00
66	Хангамжийн материал	45,945,993.08	52,809,724.92
67	Бичиг хэргийн материал	15,733,344.8	27,794,176.64
68	Аж ахуйн материал	15,901,703.28	17,627,603.28
70	Түлш шатах тослох материал	3,000,000.00	0
71	Бэлэн бүтээгдэхүүн	2,011,000.00	645,250.00
72	Хүнсний материал	3,161,050.00	1,249,050.00
73	Бусад хангамжийн материал	6,138,895.00	6,138,895.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	912,437,833.75	1,017,699,746.57
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	912,437,833.75	1,017,699,746.57
108	Биет хөрөнгө	854,139,833.75	958,551,746.57
109	Барилга, байгууламж	688,374,671.93	686,575,071.93
110	Хуримтлагдсан элэгдэл	-168,403,628.00	-178,096,466.00
111	Авто тээврийн хэрэгсэл	27,335,000.00	27,335,000.00
112	Хуримтлагдсан элэгдэл	-27,335,000.00	-27,335,000.00
113	Машин, тоног төхөөрөмж	439,985,874.22	404,500,274.22
114	Хуримтлагдсан элэгдэл	-192,018,116.45	-127,692,240.87
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	99,284,291.6	119,926,868.00
116	Хуримтлагдсан элэгдэл	-82,064,663.72	-21,284,379.32
122	Бусад үндсэн хөрөнгө	79,177,870.75	83,958,300.75
123	Хуримтлагдсан элэгдэл	-49,568,099.9	-48,707,315.46
124	Ном	39,371,633.32	39,371,633.32
126	Биет бус хөрөнгө	58,628,000.00	59,148,000.00
127	Програм хангамж	2,030,000.00	1,015,000.00
128	Хасагдуулга	-1,700,000.00	165,000.00
129	Бусад биет бус хөрөнгө	57,968,000.00	57,968,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,232,474,658.00	1,260,201,975.00
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	94,096,750.00	42,498,500.00
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	94,096,750.00	42,498,500.00
164	Өглөг	94,096,750.00	42,498,500.00
170	Бусад өглөг	94,096,750.00	42,498,500.00
171	Байгууллагад төлөх өглөг	94,096,750.00	42,498,500.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,138,377,908.00	1,217,703,475.00
215	Засгийн газрын хувь оролцоо	1,138,377,908.00	1,217,703,475.00
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	559,715,955.65	559,715,955.65
217	Өмч: -Төрийн өмч	559,715,955.65	559,715,955.65

223	Хуримтлагдсан үр дүн	194,778,127.72	274,103,694.72
224	Өмнөх үеийн үр дүн	-12,632,264.32	194,778,127.72
225	Тайлант үеийн үр дүн	207,410,392.04	79,325,567.00
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	383,883,824.63	383,883,824.63
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,232,474,658.00	1,260,201,975.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,408,957,537.4	1,727,315,129.84
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,515,837.4	204,400,829.84
77	Нийтлэг татварын бус орлого	38,515,837.4	204,400,829.84
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,067,100.00	
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,067,100.00	
84	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	33,312,230.00	197,373,698.00
85	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	4,136,507.4	7,027,131.84
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,370,441,700.00	1,522,914,300.00
143	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,238,844,400.00	1,179,272,100.00
145	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт орон нутаг	131,597,300.00	1,179,272,100.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,201,547,145.36	1,640,515,522.84
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,201,547,145.36	1,640,515,522.84
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,171,316,082.98	1,414,857,812.09
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	804,230,308.00	951,888,005.14
151	Цалин	446,966,374.03	487,947,735.00
152	Нэмэгдэл цалин	280,819,702.00	362,528,862.14
153	Унаа хоолны хөнгөлөлт		26,615,000.00
154	Урамшуулал	76,444,231.97	74,796,408.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,426,967.97	111,749,201.38
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	66,093,867.97	72,718,001.38
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	8,583,400.00	9,758,000.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,291,600.00	4,878,700.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	4,291,600.00	4,878,700.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	17,166,500.00	19,515,800.00
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,849,337.62	155,138,389.25
165	Гэрэл цахилгааны зардал	6,734,937.62	8,040,261.25
166	Түлш, халаалтын зардал	116,114,400.00	147,098,128.00
170	Хангамж, бараа материалын зардал	18,389,700.00	14,928,780.00
171	Бичиг хэргийн материал	3,908,700.00	4,534,700.00
172	Тээвэр, шатахууны зардал	4,182,100.00	4,942,080.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	10,298,900.00	5,452,000.00
181	Нормативт зардал	51,369,646.00	68,020,550.00
182	Эм	2,000.00	59,000.00
183	Хоол	51,367,646.00	67,961,550.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл		

185	Эд хогшил, урсгал засварын зардал	3,431,100.00	3,591,200.00
188	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		
189	Урсгал засвар	3,431,100.00	3,591,200.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,681,702.31	8,718,731.14
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	928,600.00	520,180.00
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	3,753,102.31	8,198,551.14
209	Бараа үйлчилгээний бусад зардал	65,937,321.08	100,822,955.18
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,935,221.08	92,111,785.18
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,231,062.38	225,657,710.75
228	Бусад урсгал шилжүүлэг	27,183,100.00	39,453,900.00
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	7,615,600.00	8,983,900.00
237	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж	19,567,500.00	30,470,000.00
238	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,047,962.38	186,203,810.75
269	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	207,410,392.04	86,799,607.00
278	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		7,474,040.00
288	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		-7,474,040.00
289	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	207,410,392.04	79,325,567.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,371,508,800.00	1,522,914,300.00
78	Нийтлэг татварын бус орлого	1,067,100.00	
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,067,100.00	
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,067,100.00	
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,067,100.00	
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,370,441,700.00	1,522,914,300.00
143	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,238,844,400.00	1,179,272,100.00
144	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт орон нутаг	131,597,300.00	343,642,200.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,142,126,928.28	1,601,370,337.66
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,142,126,928.28	1,601,370,337.66
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,110,408,465.9	1,377,078,376.91
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	804,230,308.00	951,888,005.14
151	Үндсэн цалин	446,966,374.03	487,947,735.00
152	Нэмэгдэл	280,819,702.00	362,528,862.14
153	Унаа хоолны хөнгөлөлт		26,615,000.00
154	Үр дүнгийн урамшуулал	76,444,231.97	74,796,408.00
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	100,426,967.97	111,749,201.38
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	66,093,867.97	72,718,001.38
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	8,583,400.00	9,758,000.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,291,600.00	4,878,700.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	4,291,600.00	4,878,700.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	17,166,500.00	19,515,800.00
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	124,549,337.62	152,138,389.25
165	Гэрэл цахилгааны зардал	6,734,937.62	8,040,261.25

166	Түлш, халаалтын зардал	117,814,400.00	144,098,128.00
181	Нормативт зардал	49,704,500.00	63,613,900.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	5,300,000.00
189	Урсгал засвар	4,000,000.00	5,300,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,681,702.31	8,718,731.14
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	928,600.00	520,180.00
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,753,102.31	8,198,551.14
201	Бараа үйлчилгээний бусад зардал	22,815,500.00	81,234,500.00
202	Бараа үйлчилгээний бусад зардал	18,126,490.00	75,413,200.00
203	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,689,010.00	5,821,300.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,670,500.00	224,291,960.75
225	Бусад урсгал шилжүүлэг	21,054,900.00	38,088,050.00
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	7,615,600.00	8,983,900.00
234	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,047,962.38	186,203,810.75
251	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	229,381,871.72	-78,456,037.66
264	Дотоод эх үүсвэрээр	55,107,300.00	
276	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	55,107,300.00	
279	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-55,107,300.00	
304	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	174,2744,571.72	-78,456,037.66
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,725,166.60	210,999,588.32
306	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	210,999,588.32	132,543,550.66

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	559,715,955.65	383,883,824.63	194,778,127.72	1,138,377,908.00
10	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	559,715,955.65	383,883,824.63	194,778,127.72	1,138,377,908.00
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			79,325,567.00	79,325,567.00
18	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	559,715,955.65	383,883,824.63	274,103,694.72	1,217,703,475.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ЭЗА	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		210,999,588.32
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,733,913,900.00	1,601,370,337.66
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,733,913,900.00	1,601,370,337.66
4	Бараа, үйлчилгээний зардал	1,733,913,900.00	1,377,078,376.91
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,053,134,200.00	951,888,005.14
6	Үндсэн цалин	589,258,900.00	487,947,735.00
7	Нэмэгдэл	411,673,800.00	362,528,862.14
8	Унаа, болон бусад нөхөн олговор	0	26,615,000.00

9	Урамшуулал	52,201,500.00	74,796,408.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,640,700.00	111,749,201.38
12	Тэтгэврийн даатгал	89,515,500.00	72,718,001.38
13	Тэтгэмжийн даатгал	10,531,600.00	9,758,000.00
14	ҮОМШӨ ний даатгал	5,265,400.00	4,878,700.00
15	Ажилгүйдлийн даатгал	5,265,400.00	4,878,600.00
16	Эрүүл мэндийн даатгал	21,062,800.00	19,515,800.00
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	340,142,200.00	152,138,389.25
18	Гэрэл цахилгаан	14,490,700.00	8,040,261.25
19	Түлш, халаалт	323,694,300.00	144,098,128.00
20	Цэвэр, бохир ус	1,957,200.00	
30	Нормативт зардал	63,613,900.00	63,613,900.00
32	Хоол, хүнс	63,613,900.00	63,613,900.00
34	Эд хогшил худалдан авах	3,500,000.00	5,300,000.00
38	Урсгал засвар	3,500,000.00	5,300,000.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	14,719,700.00	11,698,731.14
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	520,200.00	520,180.00
49	Мэдээллийн технологийн зардал	14,199,500.00	11,098,551.14
50	Бараа үйлчилгээний бусад зардал	81,926,300.00	81,234,500
51	Бараа үйлчилгээний бусад зардал	76,105,000.00	75,413,200.00
53	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,821,300.00	5,821,300.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,639,900.00	224,291,960.75
70	Бусад урсгал шилжүүлэг	28,639,900.00	38,088,050.00
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		186,203,810.75
80	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,639,900.00	29,104,250.00
106	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,390,271,700.00	1,179,272,100.00
109	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт орон нутаг	343,642,200.00	343,642,200.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,725,166.6	210,999,588.32
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	210,999,588.32	132,543,550.66
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	31	29
134	Удирдах ажилтан	1	1
135	Гүйцэтгэх ажилтан	20	18
136	Үйлчлэх ажилтан	10	10

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

SORT	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
200	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	343,642,200.00	343,642,200.00	100.00
201	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	343,642,200.00	343,642,200.00	100.00
202	Бараа, үйлчилгээний зардал	343,642,200.00	343,642,200.00	100.00
215	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	340,142,200.00	338,342,200.00	100.00

216	Гэрэл цахилгаан	14,490,700.00	8,040,261.25	99.5
217	Түлш, халаалт	323,694,300.00	144,098,128.00	44.5
218	Цэвэр, бохир ус	1,957,200.00	0	100.00
232	Төвлөрүүлэх шилжүүлэг		186,203,810.75	100.00
236	Урсгал засвар	3,500,000.00	5,300,000.00	100.00
298	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	343,642,200.00	343,642,200.00	100.00
299	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	343,642,200.00	343,642,200.00	100.00
1765	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			100.00
1771	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	343,642,200.00	343,642,200.00	100.00
1772	Орон нутгийн төсвөөс	343,642,200.00	343,642,200.00	100.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,046.5 мянгантөгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,069.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулан гаргуулж, 1,977.5 мянган зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

3.1 Залруулсан алдаа: Үндсэн хөрөнгийн тавилга эд хогшил дансанд 4,069.0 мянган төгрөгийн хөрөнгийг илүү бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.", 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Төлбөрийн акт:

Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 85,000 төгрөгийн хоолны зардлыг давхардуулан, ёс зүйн дээд хорооны гишүүдэд 1,892,484 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2" Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно.", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2-д "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ", 2.2.1-д "унааны зардал", 2.2.2-д "байрны зардал", 2.2.3-д "хоолны зардал" гэж заасныг тус тус зөрчсөн тул төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага өгсөн.

3.4 Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруу-лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн тавилга эд хогшил дансанд 4,069.0 мянган төгрөгийн хөрөнгийг илүү бүртгэсэн.	1	4,069.0			1	4,069.0	1	4,069.0				
Дүн	1	4,069.0			1	4,069.0	1	4,069.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ёс зүйн дэд хорооны гишүүдэд 1,892.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	1,892.5	1	1,892.5								
Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 85.0 мянган төгрөгийн хоолны мөнгө давхардуулан олгосон.	1	85.0	1	85.5								
Дүн	2	1,977.5	2	1,977.5								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД

Х.БОЛДБААТАР

Д.БАТ-УНДРАА

Огноо: 2026-01-19

БОЛОВСРУУЛСАН:

"АЛТАН ТОСОН АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТОР

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж.ТУНГАЛАГ

Б.ДАГВАСҮРЭН

Огноо: 2026-01-19